



МОНГОЛ УЛСЫН
ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН
ГИШҮҮНИЙ ЗӨВЛӨМЖ

2023 оны 03 дугаар сарын 03

№ 03/20

Улаанбаатар хот

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГА, ХУРАНДАА ТАНАА

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 6 дугаар хорооны иргэн Комисст хандаж "... Миний бие ХХК-тай орон сууц захиалгаар бариулах гэрээ байгуулсан бөгөөд тус компани гэрээний үүргээ биелүүлээгүй тул Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргаж тус шүүхийн шийдвэрээр надад 75.657.780 төгрөг олгохоор шийдвэрлэсэн юм. Шүүхийн энэхүү хүчин төгөлдөр шийдвэрийг

ХХК сайн дураар биелүүлэхгүй байсан тул Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн захирамж мөн өдрийн гүйцэтгэх хуудас бичигдэж дээрх шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэхийг Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт даалгасан. Албадан гүйцэтгэх шийдвэр гараад 2 жилийн хугацаа өнгөрч байгаа боловч Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас энэхүү шүүхийн шийдвэрийг биелүүлэх талаар тодорхой арга хэмжээ авахгүй өдийг хүрлээ" гэх гомдлыг ирүүлжээ.

Комисс гомдлын мөрөөр холбогдох албан тушаалтнаас тайлбар, тодруулга авах, гомдолд хавсаргаж ирүүлсэн баримт, эрх зүйн зохицуулалтад дүн шинжилгээ хийхэд дараах нөхцөл байдал тогтоогдож байна. Үүнд:

1. Иргэн ХХК-тай 2013 оны 03 дугаар сарын 30-ны өдөр 19 дугаартай орон сууц захиалгаар бариулах гэрээ байгуулсан байх бөгөөд тус компани гэрээний үүргээ биелүүлээгүй тул Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргаж тус шүүхийн 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 181/ШШ2020/02940 дугаар шийдвэрээр түүнд 75.657.780 төгрөг олгохоор шийдвэрлэсэн байна.

2. Шүүхийн энэхүү хүчин төгөлдөр шийдвэрийг сайн дураар биелүүлэхгүй байсан тул Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2021 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 181/ШЗ2021/00762 дугаар захирамж мөн өдрийн 181/ГХ2021/00046 дугаар гүйцэтгэх хуудас бичигдэж дээрх шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэхийг Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт даалгажээ.

3. Комисс гомдлын мөрөөр иргэн нэхэмжлэлтэй ХХК-д холбогдох шийдвэр гүйцэтгэх ажиллагаа биелэгдэхгүй байгаа шалтгаан, холбогдох тайлбар, мэдээллийг ирүүлэх талаар 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн ТГ-05/83

дугаар албан бичгийг Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт хүргүүлсэн бөгөөд тус газраас 2023 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 1-184/1996 дугаар албан бичгээр ирүүлсэн тайлбартаа “төлбөр төлөгч-хуулийн этгээд эд хөрөнгөгүй, үйл ажиллагаа явуулаагүй, татвар тайлагнадаггүй мөн шүүхийн шийдвэрийн дагуу Нийслэлийн Засаг даргаас гаргуулан авах авлага шийдэгдээгүй байгаагаас шийдвэр гүйцэтгэх ажиллагаа удааширч байна” гэжээ.

4. Дээрх албан бичигт хавсаргаж ирүүлсэн материалтай танилцахад Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын Тасгийн дарга бөгөөд Сүхбаатар дүүргийн ахлах шийдвэр гүйцэтгэгч, дэслэгч 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 21280184 дугаар тогтоолоор төлбөр төлөгч _____ д холбогдох гүйцэтгэх баримт бичигт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсгэж, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг мөн өдрөөс эхлүүлэхийг 184 дүгээр тойргийн шийдвэр гүйцэтгэгч, дэслэгч Ч.Энхтуяад зөвшөөрсөн байна.

5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсээд даруй 2 жилийн хугацаа өнгөрсөн байх боловч ямарч төлөлт хийгдээгүй, төлбөр төлөгч нь нийт 8 иргэнд 679.683.344 төгрөгийн төлбөрийн үлдэгдэлтэй байна.

6. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.3 дахь хэсэгт “Хэд хэдэн гүйцэтгэх баримт бичгийн дагуу хэд хэдэн төлбөр авагчийн хөрөнгийн шинжтэй шаардлагыг гүйцэтгэх баримт бичиг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад бүртгэгдсэн дарааллын дагуу хангах бөгөөд, эхний гүйцэтгэх баримт бичигт заасан шаардлагыг бүрэн хангаснаар дараагийн гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг хангах зарчмыг баримтална” гэж заасан боловч гомдол гаргагч _____, уушигны хорт хавдар оноштой Бүгд найрамдах Энэтхэг улсад удаан хугацааны эмчилгээ хийлгэж байгаа нөхцөл байдлыг харгалзан түүний Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээ конвенцоор баталгаажуулсан эрүүл мэндээ хамгаалуулах эрхийг хангахын тулд энэхүү шүүхийн шийдвэрийг аль болох богино хугацаанд гүйцэтгэх шаардлагатай байна.

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэгт “Хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг хүн, хуулийн этгээд заавал биелүүлэх үүрэгтэй”, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэгт “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн хууль ёсны шаардлагыг үл биелүүлсэн, эсхүл хуульд заасан үндэслэл, журмын дагуу явуулж байгаа шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулсан хүн, хуулийн этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ”, Зөрчлийн тухай хуулийн 15.2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.1-д “төрийн албан хаагчаас тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй, хүнийг хоёр зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэж тус тус хуульчилсан.

Иймд иргэн _____ зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх, Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээ конвенцоор баталгаажуулсан эрүүл мэндээ хамгаалуулах эрхийг хангахын тулд шүүхийн шийдвэрийг аль болох богино хугацаанд гүйцэтгүүлэх зорилгоор Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 27 дугаар

зүйлийн 27.3 дахь хэсэгт заасан Комиссын гишүүний бүрэн эрхийн хүрээнд энэхүү Зөвлөмж хүргүүлэв.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1, 28.2 дахь хэсэгт заасны дагуу зөвлөмжийн мөрөөр авсан арга хэмжээний танилцуулгыг, холбогдох баримтын хамт 30 хоногийн дотор ирүүлнэ үү.

Хувийг гомдол гаргагчид.

ГИШҮҮН  Х.МӨНХЗУЛ

